



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 463

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.4, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 382,797,836.58 (гурван зуун наян хоёр сая долоон зуун ерэн долоон мянга найман зуун гучин зургаан төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 42,733,150.75 (дөчин хоёр сая долоон зуун гучин гурван мянга нэг зуун тавин төгрөг далан таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 12 нэрийн үл хөдлөх хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Түвшинтогтоход дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг байгууллагын мэдэлд хэвээр үлдээж албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4. Авсан арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2020 оны 09 дугаар сарын 22 ны өдрийн  
 463 дугаар тогтоолын хавсралт

**ШИНЖЛЭХ УХААН БОТАНИКИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН  
 ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ АКТЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ /2020.09.30-ны байдлаар/	Үлдэх өртөг /төгрөг/
1	Автомашины граж	1988.01.01	98,000,255.91	7,583,353.18	90,416,902.73
2	Агуулахын ягаан байр	1957.01.01	26,129,015.92	2,021,888.18	24,107,127.74
3	Аж ахуйн агуулах	1990.01.01	56,149,131.35	3,379,345.84	52,769,785.51
4	Угсармал бетонон хашаа	1988.01.01	7,994,896.00	787,376.07	7,207,519.93
5	Уурын зуухны байшин	1969.01.01	69,010,289.80	6,796,467.99	62,213,821.81
6	Хүлэмж	1957.01.01	3,402,330.00	614,309.54	2,788,020.46
7	Цахилгааны дэд өртөөний байр	1983.01.01	7,818,300.00	352,909.44	7,465,390.56
8	Худаг	2012.06.17	22,805,755.12	1,375,130.28	21,430,624.84
9	Бетонон талбай	2008.01.01	1,858,380.00	402,649.00	1,455,731.00
10	Төмөр хашаа	1988.01.01	28,023,578.40	6,071,775.32	21,951,803.08
11	Ургуулангийн хүлэмжийн байр	1989.01.01	56,502,409.08	12,242,188.66	44,260,220.42
12	Шилэн хүлэмж	1989.01.01	5,103,495.00	1,105,757.25	3,997,737.75
			<b>382,797,836.58</b>	<b>42,733,150.75</b>	<b>340,064,685.83</b>
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>(гурван зуун наян хоёр сая долоон зуун ерэн долоон мянга найман зуун гучин зургаан төгрөг тавин найман мөнгө)</b>	<b>(дөчин хоёр сая долоон зуун гучин гурван мянга нэг зуун тавин төгрөг далан таван мөнгө)</b>	<b>(гурван зуун дөчин сая жаран дөрвөн мянга зургаан зуун наян таван төгрөг наян гурван мөнгө)</b>